

**Монгол Улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчин
бусад орны татварын орчны харьцуулсан судалгаа**

1. Монгол Улсын Уул уурхайн салбарыг олон улсын судалгааны байгууллага, судлаачид хэрхэн ойлгож, сурталчилж байгаа байдалд өгөх үнэлгээ, санал, зөвлөмж
2. Профессор Жеймс Оттогийн буюу Эрдэс баялагийн салбарын хуульч, эдийн засагчийн хийсэн судалгаа
3. Монгол Улсын уул уурхайн салбарын татварын орчин
 - 3.1. Уул уурхайн салбарт үйлчилж байгаа татварууд
 - 3.2. Татварын ачааллын судалгаа
 - 3.3. Бусад улсуудын татварын ачаалал
 - 3.4. Дүгнэлт

ӨМНӨХ ҮГ

Уул уурхайн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт, татвар, эрх зүйн орчин, түүхий эд бүтээгдэхүүний үнэ, ханш, эрэлт, хэрэгцээ дэлхий дахинд жил, сар, өдрөөр бус цаг, минутаар өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа эрчимтэй хөгжлийн цаг мөчид Та бид ажиллаж байна. Тиймээс ирээдүйг урьдчилан харж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, гүйцэтгэх үйл ажиллагаагаа оновчтойгоор төлөвлөх нь улс орны хөгжилд чухал ач холбогдолтой болно.

Монгол Улсын эрдэс баялагийн олборлолтоор дэлхийн хэмжээнд үзүүлэх нөлөө өсөж буй өнөө үед Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын Уул уурхайн газраас эрхлэн гаргасан “Монгол Улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчин бусад орны татварын ачааллыг харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны ажлын тайлан, дүгнэлтийг толилуульж байна.

Дэлхийн эдийн засагт уул уурхайн салбарын үзүүлэх нөлөө, хөгжлийн хандлага, Монгол Улсын хууль эрх зүйн орчин олон улсад хэрхэн үнэлэгдэж байгаа, голлох ашигт малтмалын үнэ ханшийн цаашдийн төлвийг олон улсад энэ чиглэлээр ажилладаг судалгааны байгууллагууд, эрдэмтэд, судлаачдын судалгаа, дүгнэлтүүдийг тусган тус газрын мэдээллийн санд тулгуурлан энэхүү ажлыг гүйцэтгэсэн болно.

Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе!

АМГТХЭГ-ЫН ДАРГА



Ж.БИЛЭГСАЙХАН

Зохиогчид:

Судалгааны ажлын зөвлөх:

АМГТХЭГ-ын дарга

Ж.Билэгсайхан

Судалгааны ажлыг удирдсан:

АМГТХЭГ, УУГ, СССХ-ийн дарга

Б.Магванжав

Судлаж гүйцэтгэсэн:

АМГТХЭГ, УУГ, СССХ-ийн мэргэжилтэн

Б.Бямбадагва

АМГТХЭГ, УУГ, СССХ-ийн мэргэжилтэн

Т.Баасанпүрэв

АМГТХЭГ, УУГ, СССХ-ийн мэргэжилтэн

Э.Оюутцэцэн

Судалгааны ажлын талаарх санал хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38,
АМГТХЭГ, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Баруун жигүүр, АМГТХЭГ-ын Нэгдүгээр байр Уул уурхайн газар

Утас: 976-11-263709

Факс: 976-11-310041

E-mail: mrpam@mining.mn

Web page: <http://mrpam.gov.mn>

<http://b.byambadagva@mrpam.gov.mn>

**1. Монгол Улсын Уул уурхайн салбарыг олон улсын
судалгааны байгууллага, судлаачид хэрхэн ойлгож,
сурталчилж байгаа байдалд өгөх үнэлгээ, санал, зөвлөмж**

Фрейзерийн хүрээлэн

Фрейзерийн хүрээлэн (<http://www.fraserinstitute.ca/>) нь 1997 оноос дэлхийн улс орнуудын уул уурхайн салбарын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бие даасан судалгааны байгууллага юм. Үнэлэлт дүгнэлтийг тухайн улс, орон нутгийн уул уурхайн салбарт нөлөөлж болох үзүүлэлтүүдийг индексжүүлэн **Бодлого Боломжийн Индекс /Policy Potential Index PPI/** -ээр тодорхойлж байна.

БИБ (Боломжит индексийн бодлого) тодорхойлохдоо засгийн газраас явуулж буй бодлогууд, түүний тогтвортой байдал, хуулийн хэрэгжилт, тэдгээрийн тайлбарууд, байгаль орчиныг хамгаалах зохицуулалт, захиргаадлыг журмын давхардлууд, татвар, уугуул иргэдийн газрын эрх болон тусгай хамгаалттай газруудад хэрэгжүүлэх бодлого, дэд бүтэц, геологийн мэдээллийн сан, нийгэм эдийн засгийн яриа хэлэлцээр, улс төрийн тогтвортой байдал, боловсон хүчний нөөц, хөдөлмөр эрхлэлт болон аюулгүй орчин зэрэг үзүүлэлтүүдийг нэгтгэн 100 оноогоор тооцдог ажээ.

Тус хүрээлэн 2006-2007 оныхоо судалгааг дэлхийд хайгуул, олборлолт, судалгаа, төслийн ажил явуулж байгаа 3000 орчим байгууллагуудын мэдээллийг үндэслэн хийсэн бөгөөд уг судалгааны дүнгээр нийт 65 улсыг PPI –д авсан онооны дагуу жагсаасан. Уг жагсаалтын эхэнд тухайн улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийхэд тааламжтай, засгийн газраас нь явуулж буй бодлого нь ойлгомжтой, хуулийн хэрэгжилт сайн зэрэг үзүүлэлтүүдээрээ Австрали, Хойд Америкийн улс орнууд орсон бол жагсаалтын сүүлийг буюу уул уурхайн салбар нь маш хүнд байдалд байгаа улс орнууд, тухайлбал Зимбабве Венесуел, Боливи, **Монгол**, Филиппин,

Папуа Шинэ Гвиней, Казакстан, ОХУ, Ардчилсан Конго, Индонез зэрэг орсон байна.

Монгол Улс БИБ –ын оноогоор 2005-2006 онд 33-р байранд буюу 54 оноотой байсан бол 2006-2007 онд 62-р байранд буюу 11 оноо авч 27 улсаар хойшлогдсон байна.

Монгол Улсын үзүүлэлт ийнхүү ухарсан нь хууль эрх зүйн орчин бүрхэг, ашиглахад хүндрэлтэй байдагтай холбоотой гэж тус улсад өнгөрсөн жил үйл ажиллагаагаа явуулсан эрдэс баялгийн хайгуулын компаниуд дүгнэжээ.

Судалгаанд хамрагдсан зарим нэг компанийн удирлага, судлаачид дараах санал илэрхийлжээ. Үүнд:

- Нэгэн олборлогч компанийн ерөнхийлөгч: **“Монгол Улс нэг шөнийн дотор л хөрөнгө оруулалтанд нээлттэй бодлогоо гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг шийтгэх бодлогоор солисон”**
- Нэгэн эрдэс баялгийн хайгуулын компанийн менежер. “Австрали бол уул уурхайн урт түүхтэй бөгөөд төрөөс зөв бодлогууд явуулдаг нь тус салбарыг сайн ойлгодогт оршиж байгаа юм”
- Нэгэн хайгуулын компанийн дэд ерөнхийлөгч: “Австрали сайн дэд бүтэц, мэдлэг мэдээлэл, улс төрийн тогтвортой байдал, нөөц баялагтай болон туршлагатай чадварлаг боловсон хүчинтэй улс юм”
- Австралид үйл ажиллагаа явуулдаг хайгуулын компанийн ерөнхийлөгч: “Куйнслэндийн байгаль орчины журам зохицуулалтыг хэрэгжүүлэх арга зарчим нь дэндүү ярвигтай, хүнд суртал дагуулсан ба зах зээлийн зарчим болон түүний хязгаарлалтыг ойлгож боловсруулаагүй, хэтэрхий үзэл сурталжсан бодлого дээр туулгуурласан. Байгаль орчины бодлогыг хялбаршуулж хүнд сурталаас арилгах хэрэгтэй”

- Нэгэн хайгуулын компанийн дэд ерөнхийлөгч: “Австралийн уугуул иргэдийн газрын эрхий асуудал бүрхэг байна. Энгийн ойлгомжтой болгомоор байна”
- Судалгаанд оролцогчид Хойд Америкийн талаар нэлээд сэтгэл өндөртэй байв. “Америк, Канад улсын хууль эрх зүйн орчин сайжирч байна. Америк байгаль орчины төрийн бус байгуулгын шахалтаар явуулж байсан цэвэр үзэл бодол дээр тулгуурласан хуучин бодлогоос татгалзаж байна. Канад улс уул уурхайн салбар нь тус улсын эдийн засгийн хөдөлгүүр хүч гэдгээ ойлгож эхэлсэн” гэж нэгэн хайгуулын компаний гүйцэтгэх захирал дурдсан байна.

Эндээс үзвэл манай улсын рейтинг буурахад улс төрийн ойлгомжгүй, тогтворгүй байдал, хууль эрх зүй, авилгал, хээл хахуул голлон нөлөөлсөн гэж үзэж болох юм.

2. Жеймс Оттогийн буюу Эрдэс баялагийн салбарын хуульч, эдийн засагчийн хийсэн судалгаа

Жеймс Отто нь олон жилийн турш уул уурхайн салбарын татвар, ашигт малтмалын хуулийн талаар судалгаа, зөвлөгөө хийж байгаа эрдэмтэн судлаач хүн юм.

Профессор Ж.Отто 2007 оны 1 сард Монгол Улсын уул уурхайн салбарын өрсөлдөх чавдарын шинжилгээ /зэсийн үйлдвэрлэлийн салбарт/ хийсэн билээ.

Уг судалгаанд уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалтаас олох өгөөж /IRR -ашигт ажиллагааны түвшин/ голлон авч үзсэн ба уг үзүүлэлтийг дэлхийн бусад улс орнуудтай харьцуулж дүгнэлт хийжээ.

Профессор Ж.Отто гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтаас олох өгөөжийн хэмжээг 4 ангилалд хувааж үзжээ. **1-р ангилал**

буюу IRR өндөр, хөрөнгө оруулалт хийхэд таатай хэсэгт Швед, Австрали, Чили, Аргентин, Хятад, **2-р ангилал** буюу IRR-ийн дундаж хэсэгт Шинэ Гвиней, Боливи, Өмнөд Африк, Филиппин, Индонез, Казакстан, **3-р ангилал** буюу IRR бага хэсэгт Перу, Танзани, Польш, Америк, Мексик, Гвиней, **4-р ангилал** буюу IRR маш бага, хөрөнгө оруулалт хийхэд маш эрсдэлтэй хэсэгт Гана, Узбекистан, Канад **Монгол** улсууд тус тус оржээ.

Хөрөнгө оруулагчид тухайн төслийн хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшин 12%-аас доошгүй байгаа тохиолдолд хөрөнгө оруулдаг дэлхийн туршлага бий. Профессор Ж.Оттогийн тооцоолсноор Монгол Улсад хөрөнгө оруулалт хийснээс олох өгөөж 8.6% буюу олон улсын төсөлд хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шалгуураас доогуур гарсан бөгөөд энэ ангилалын маш бага хэсэгт буюу дээр дурдагдсан орнуудын хамгийн сүүлд орсон байна. Тиймээс хөрөнгө оруулагчид Монголыг маш эрсдэлтэй гэсэн дүгнэлтийг хийхэд хүрч байна.

Ж.Оттогийн тооцоолсноор Монгол Улс өмнө нь буюу Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар шинээр бий болоогүй байхад **2-р ангилал буюу IRR нь 12.8,% байсан** байна. Өөрөөр хэлбэл Шинэ Гвиней, Болив, Өмнөд Африк, Филлифин, Индонез, Казакстан зэрэг улсуудтай өрсөлдөх чадвар нь ойролцоо байжээ.

Дүгнэвэл 2006 он гарсаар хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшин 4.2%-иар буурч хамгийн бага өгөөжтэй түвшин хүртэл 2 шатлал буурсан байна.

Дээрхи хоёр судалгаанаас үзвэл дүгнэвэл Монгол Улсын уул уурхайн салбарын нэр хүнд дэлхийд, гадны томоохон хөрөнгө оруулагчдын дунд унажээ. Үүнд улс төрийн ойлгомжгүй, тогтворгүй байдал /гэнэт шинэ төрлийн татвар бий болгох гм/, байгаль орчныг хамгаалах зохицуулалт, иргэдийн эсэргүүцэл, тэдний тавьж буй шаардлага, татварын ачаалал голлон нөлөөлсөн байна.

Энэ дүгнэлт хэр бодитой, үнэн эсэхийг шалгах зорилготойгоор АМГТХЭГ-ын Уул уурхайн газар 2007 оны 2 дугаар сард Татварын хуулийн өөрчлөлт, Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга болон Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулийн дагуу Уул уурхайн салбар дахь татварын ачаалал хэрхэн өөрчилөгдөж байгаа талаарх судалгаа хийсэн болно.

Судалгааны дүгнэлтэнд Монгол Улсын уул уурхайн салбар дахь татварын ачаалал 1997-2003 оныг хүртэл тогтвортой байсан бол 2004-2005 онд буурсан юм. Гэтэл 2006 он гарсаар энэ үзүүлэлт 5-17% /алт болон зэс/ - аар өссөн. Шалтгааныг тодруулбал татварын хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор нийт татварт эзэлдэг орлогын албан татвар 20-30% буурсан бол ЗБҮӨТатвар нэртэй шинэ татвар бий болж нийт татварын 50%-ыг эзэлдэг болсон байна.

Уул уурхайн салбар дахь татварын ачаалалд ЗБҮӨТатвар 50% нөлөөлж байгаа бөгөөд энэ татварын хувь хэмжээ алт болон зэсийн дэлхийн зах зээлийн үнэ ханшаас хамааран өөрчилөгдөхөөр байгаа юм. Өөрөөр хэлбэл уул уурхайн салбар дахь татварын ачаалал тогтворгүй буюу дэлхийн зах зээл дээрх металлын үнийн өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөж байхаар байна.

Дүгнэлт

1. Гадаадын нэр хүнд бүхий байгууллага, судлаачдын дүгнэлтээр зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар нь уул уурхайн салбар дахь татварын ачаалал, хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтворгүй болгосон ба төрийн бодлого, хуулийн хэрэгжилт нь салбарыг тогтворгүй болгоход хүргэсэн байна.
2. Хууль эрх зүйн орчинд хийсэн шинэчлэл хөрөнгө оруулалтанд тийм ч сайн үр дүнг дагуулахгүй байгаа нь ажиглагдлаа. Гол нь хууль эрхзүйн орчин гэнэт

өөрчлөгддөг болсон нь хөрөнгө оруулагчдын сонирхолд огт нийцэхгүй байна. Харин ч тэднийг болгоомжлох, хүлээцтэй байдалд оруулж байна.

3. Иргэдийн уул уурхайн салбар болон түүний хууль эрхзүй, гэрээ хэлэлцээрийн талаарх мэдээллийг сайжруулах тэдний буруу ойлголтыг залруулах арга хэмжээнүүдийг шат дараалан авах, хөрөнгө оруулагчдад хандаж байгаа таагүй уур амьсгалыг аль болох зөөллөх бодлого хэрэгжүүлэх шаардлагатай юм.

4. Геологи хайгуулын ажлын явц, геологийн тогтоцоор Монгол Улс эрдэс баялагийн салбарын хөрөнгө оруулах боломжтой орнуудын тоонд багтсаар байгаа бөгөөд 2006 оны хайгуулын ажилд зарцуулсан зардлаар эхний 10-ын 9-д нь багтсан байна./MEG-Metal Economic Group-ийн мэдээгээр/ Энэ юу хэлж байна вэ гэвэл өмнө нь хөрөнгө оруулалтаа нэгэнт хийсэн аж ахуйн нэгжүүдийн хийсэн ажлын үр дүн л харагдаж байгаа гэж ойлгох нь зүйтэй. Үндэсний компаниуд ч чамлахааргүй ажилласаны үр дүн олох билээ. Тэрнээс шинээр орж ирээд хөрөнгө гарган хайгуул хийсэн юм байхгүй.

5. Уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалт зайлшгүй шаардагдана. Өнөөдөр ч гэсэн Монголоор зогсохгүй өндөр хөгжилтэй, хөрөнгөжсөн орнууд болох АНУ, Австрали, Канад, ОХУ, Хятад бүгд л гадаадын хөрөнгө оруулалтыг уул уурхайдаа татаж ажилласанаар эдийн засгаа улам илүү хөгжүүлж чадаж байна.

Дээрхи дүгнэлтээс үзвэл:

Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжлийг сааруулах дараах хүчин зүйлүүд байна гэж үзэж байна. Үүнд:

1. Зарим бараанд (алт, зэсийн) үнийн өсөлтийн татвар ноогдуулах тухай хууль
2. 2007 оны 7 сард баталсан Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалтууд буюу Стратегийн ач холбогдолтой орд газруудад хувийн хөрөнгөөр хайгуул хийвэл 34 хүртэл хувь, улсын төсвийн хөрөнгөөр

хайгуул хийгдсэн бол 50 хүртлэх хувийг тус тус төр эзэмшиж болох тухай заалт.

Үндсэндээ энэ хоёр хуулийн холбогдох заалтуудын үйлчлэлээр Монгол улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх нөхцөл бололцоог ихээхэн муутгалаа.

Энэ хуулийн заалтууд хэрэгжиж эхэлснээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж байсан Канадын хөрөнгө оруулалттай компаниуд Торонтогийн хөрөнгийн бирж дээр 1.3 Тэр бум долларын хөрөнгийг алдсан. Эдгээр хөрөнгийн 20 % ийг өнгөрсөн онд ашиглаж чадсан бол доод тал нь 265 сая ам.долларын хөрөнгө оруулалт орохын зэрэгцээ 2007 онд түүнээс ч их хэмжээний хөрөнгө Монголын эдийн засагт орж ирэх бололцоотой байх байлаа.

Энэ бүх хүчин зүйлүүд цаашид Монголд олон том, жижиг ордууд нээгдэх бололцоо, боломжийг хааж байна.

Хамгийн гол нь Торонтогийн болон бусад хөрөнгийн бирж дээр нэр хүндээ алдсан нь Монголын орд газруудыг санхүүжилтийн бололцоо үндсэндээ хаагдах шинжтэй болсон байгааг анхаарах хэрэгтэй байна. Гол нь томоохон төслүүдийн санхүүжилтийг хувьцаа эзэмшигчидийн хөрөнгөөр босгодог ба одоогоор хувьцаа эзэмшигчид дахин Монголын Засгийн газарт итгэх итгэл нь алдарсан гэж үзэж байна. Учир нь Монголын хууль тогтоомжууд тогтвортой мөрдөгддөггүй богино хугацаанд ихээхэн өөрчлөгдөж, тогворгүй байгаа бөгөөд сүүлийн саруудад хувийн хөрөнгийг нийгэмчлэх хандлага гарч байна гэсэн ойлголт газар авсан нь хамгийн их болгоомжлолыг төрүүлж байна.

Тийм ч учраас сүүлийн саруудад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт эргээд хууль эрх зүйн орчин тогтвортой байдаг АНУ, Канад ялангуяа Австралийн Куйнслэнд муж руу урсах хандлага гарч байгаа тухай мэдээ дэлхийд цацагдах болов.

Монгол улс харилцан ашигтай хөрөнгө оруулалтыг дэмжих ёстой. Гагцхүү хэт их ашиг олох гэж туйлшраад төлөвшиж буй тогтвортой байдлыг эсрэгээр эргүүлж эхэллээ.

Тодорхой жишээ авъя. Бидний сайн мэдэх Эрдэнэтийн хайгуулын ажлыг эхлэн үйлдвэр байгуулан эхний ээлжийг хүлээн авах хүртлээ хөрөнгө мөнгөний сааталгүй, шахуу төлөвлөгөөтэй ажиллахад нийт 18 жил шаардсан. Энэ уурхай байгуулагдсанаасаа хойш 30 жил Монгол Улсын эдийн засгийг тэтгэж байгаа ба цаашид ч 30-40 жил ажиллах бололцоотой боловч металлын үнэ огцом унавал дампуурахад ойрхон байна.

Бидэнд Эрдэнэт шиг ордыг ашиглахаа больё, харин зөвхөн түүнийг олж нээн илрүүлэх хөрөнгө, санхүүгийн, техник - технологийн, мэргэжилтэй боловсон хүчний бололцоо байна уу гэдэг эргэлзээтэй бөгөөд ердөө л санхүүжилтийг хаанаас гаргах вэ гэсэн асуудал гарах юм. Бидний мэдэх мэдэхгүй бусад олон хүчин зүйлээс шалтгаалахаар байна.

Ашигт малтмалын үнэ үргэлж өндөр байддаггүй. Өндөр хөгжсөн орнуудын хувьд томоохон бүтээн байгуулалт хийх, эдийн засгийн боломж гаргаагүй тохиолдолд металлын хэрэглээ тэр бүр өсдөггүй. Хятадын хувьд 2008 оны олимп зохион байгуулах, шинээр барьж байгуулах томоохон үйлдвэрийн төвүүд барихтай уялдаатай металлын хэрэглээ одоохондоо өндөр байна. Түүний зэрэгцээ дэлхийн өндөр хөгжилтэй орнууд хаягдал металлын 40-60 гаруй хувийг эргүүлэн ашиглаж тухайн түүхий эдийг шинээр олборлон боловсруулахаас хамаагүй бага өртгөөр зах зээлд нийлүүлж байна. Сүүлийн жилүүдэд аливаа металлыг орлуулах хямд өртөг бүхий эрдэс түүхий эдийг үйлдвэрийн түвшинд туршин хэрэглэж эхэлснээр тухайн металлыг их хэмжээгээр орлуулах бололцоо бүрдэж байна. Нано технологи ч шинэ хэтийн төлвийн дүр зураг гаргаж байна.

Хүн төрөлхтөн эрт цагаас аливаа зүйлийг хямд төсөр өртгөөр орлуулах арга замыг цаг ямагт эрэлхийлсээр ирсэн ба цаашид ч шинжлэх ухааны ололт амжилтад тулгуурлан түүнийгээ хийсээр байх болно. Дэлхийд алт, мөнгө, зэс, төмрийн нөөц дуусвал эдгээр металлгүйгээр хүн төрлөхтөн амьдарна.

Хамгийн наад захын жишээ гэхэд утасгүй хөдөлгөөнт холбооны технологи нэвтэрснээр асар ихээр хэрэглэгдэх байсан зэс, хөнгөн цагаан утсыг огт хэрэглэхгүй болж чадлаа. Дэлхийн нефтийн нөөц дууссан ч хүн төрөлхтөн эрчим хүчний хэрэглээнээс шалтгаалан ургамал, нүүрс, устөрөгч, нар салхи гээд олон зүйлээс эрчим хүч гаргаж авдаг болно. Иймд аливаа зүйлийг үнэ хүрч байгаа үед нь ашиглаж хөрөнгийн хуримтлал бий болгох, улс орноо хөгжүүлэх нь зүйтэй юм.

Өвөг дээдсийн өвлүүлж өгсөн баялагийг хожим үедээ үлдээж зөвхөн өөрсдөө олон мянган жилдээ хэрэглэнэ гээд улс төржсөөр байтал дэлхийн дэвшил биднийг хүлээхгүй хол явна гэдгийг анхаарах цаг болжээ.

Зөвлөмж

Монгол Улс байгалын баялаг нөөц ихтэй орны тоонд ордог. Гэвч энэ нь улс орны эдийн засгийн хөгжүүлэх гол үзүүлэлт биш юм. Дэлхийн ихэнх эдийн засагчдын үзэж байгаагаар эдийн засгийг хөгжүүлэх гол үзүүлэлт нь эдийн засгийн эрх чөлөө гэж тодорхойлж байна. Харин байгалын баялаг, газар зүйн байршил нь тухайн улс орны эдийн засгийг дэмжих боломжийг авчирдаг гэж тэд үзэж байна. Үүний тод жишээ бол ямар ч эрдсийн баялагаар хомс Япон улсын эдийн засгийн хөгжил юм. Өртөг өндөр учир ашигладаггүй эрдэс баялаг их бий; Шохой, цемент, Австралиас гаргадаг нүүрс авдаг, алт, зэс, хар тугалаг гэх мэт.

Иймд Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн эрх чөлөөг дэмжих бодлогыг баримтлах нь зүйтэй. Үүний тулд ойлгомжгүй, тогтворгүй байдлыг арилгах хэрэгтэй байгаа ба энэ байдлыг бий болгож гадаадын томоохон хөрөнгө оруулагчдыг үргээж буй Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татаварын хуулиа дахин эргэж харах нь зүйтэй юм.

Монгол Улсад уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг баримтлахад дараах хуулийн заалтуудыг яаралтай өөрчлөх шаардлагатай. Үүнд:

1. Гэнэтийн ашгийн татварын тухай хуулийг өөрчлөх. Энд дараахи хувилбарууд байж болно.
 - Энэ хуулийг бүхэлд нь хүчингүй болгох,
 - Зөвхөн алтанд оногдуулах татварыг хүчингүй болгох ба Харин зэсийн үнэд оногдуулах тохиолдолд зөвхөн үйлдвэр баригдаад хөрөнгө оруулалтаа нөхсөнөөс хойш оногдуулж болно гэж өөрчлөх
 - Судалгааны үндсэн дээр татварын ачааллын өрсөлдөх түвшин сонгоход алтанд 650 ам.доллар/унц, зэсэнд 4000 ам.доллар/тн /татварын ачааллын хэвийн түвшин дэх тохиромжит үнэ/
2. АМТХ ийн 5.5 дугаар заалтыг хүчингүй болгох, эсвэл улсын хөрөнгө оруулах арга замыг маш тодорхой болгож өгөх. Үүнд:
 - а. Equity financing буюу компанийн дүрмийн санд хувь оруулж түүнд оруулсан хувь хэмжээгээрээ хөрөнгө оруулалт хийх
 - б. Дэд бүтцийг буюу эрчим хүчний болон төмөр замын байгууламжийг барьж байгуулах замаар нийт хөрөнгө оруулалтын тодорхой хувийг эзэмших гэх мэтээр хуулийн заалтыг маш тодорхой болгох шаардлагатай.
 - в. Бэлчээр, экологийн тохиромжит нөхцлийг хомсдлын хувь хэмжээг тогтоох замаар хөрөнгө оруулалтын хувь эзэмших.
3. Улс орны эрх ашгийн үүднээс уул уурхайн салбар руу чиглэсэн сөрөг нөлөө бүхий PR-г илчлэх, таслан зогсоох талаар арга хэмжээ авах шаардлагатай болсон байгааг анхаарах.
4. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын компаниудтай харилцан ойлголцож харилцан ашигтай байх зарчмыг баримтлах
5. Үндэсний компаниудын үнэт цаасыг дэлхийн зах зээл дээр гаргах боломжийг бодлогоор дэмжих,
6. Засгийн газар уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх, тодорхой төсөл хэрэгжүүлэх зорилгоор томоохон хөрөнгийн биржүүд дээр үнэт цаас гаргах боломжийг судлах, хэрэгжүүлэх.

3. Монгол Улсын уул уурхайн салбарын татварын орчин

Монгол Улсын Татварын хуулийн өөрчлөлт, Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга болон Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулийн дагуу Уул уурхайн салбар дахь татварын ачааллын өөрчлөлтийг судлах, Уул уурхайн салбар хөгжсөн, хөгжүүлж буй бусад улсын татварын ачаалалтай харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөхөд энэхүү судалгааны зорилго оршив.

3.1. Уул уурхайн салбарт үйлчилж байгаа татварууд

Монголын Улсын уул уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулахад Ашигт малтмалын тухай хууль, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн тухай хууль, Аж ахуй нэгжийн болон Хүн амын орлогын албан татварын тухай хууль, Гаалийн албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Авто бензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль, Газрын тухай хууль, Татварын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль зэрэг хуулиуд гол үүрэг гүйцэтгэж байна.

Доорхи хүснэгтээс харахад 2004 оноос Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг өөрчилсөн бөгөөд энэ өөрчлөлтөөр өмнөх нь 100 сая дээш төгрөгийн ашигтай ажилласан бол уг түвшинээс дээш гарсан ашгийн 40%-т татвар ногдуулдаг байсан бол 30% болгож бууруулсан юм. Харин 2007 оноос эхлэн уг хуулийг дахин шинэчилэн мөрдөж байгаа бөгөөд татварын шатлалын босго 3 тэрбум төгрөг хүртэл өсөж өндөрссөн төдийгүй энэ шатлалаас доош бол 10%-ийн татвар тооцох ба үүнээс өндөр бол дээш гарсан ашигт нь 25%-ийн татвар ногдуулах юм.

Эдгээрийн хуулийн нөхцөл, татварын хувь хэмжээг хүснэгт №1.3.1-т үзүүлэв.

1.3.1. дүгээр хүснэгт

| Монгол Улсын уул уурхайн салбарын татварын орчны судалгаа | | | | | |
|-----------------------------------------------------------|----------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| д/д | Хууль болон татварын төрөл | 2003 он | 2004-2005 он | 2006 он * | 2007 он ** |
| 1 Ашигт малтмалын тухай хууль | | | | | |
| 1.1 | Хайгуулын лицензийн төлбөр /ам.доллар/га.жил/ | | | | |
| | 1 жил | 0.01 | | | 0.1 |
| | 2 жил | 0.5 | | | 0.2 |
| | 3 жил | 0.5 | | | 0.3 |
| | 4-5 жил | Б1 | | | 1 |
| | 6 жил | 1.5 | | | 1 |
| | 7 жил | 1.5 | | | 1.5 |
| | 8 жил | .* | | | 1.5 |
| | 9 жил | .* | | | 1.5 |
| 1.2 | Ашиглалтын лицензийн төлбөр /ам.доллар/га.жил/ | | | | |
| | 1-3 жил | 5 | | | |
| | 4-6 жил | 7.5 | | | |
| | 7-түүнээс дээш | 10 | | | |
| 1.3 | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | Алтын үндсэн ордод 2.5%, Шороон ордод 7.5%, Бусад а/м 2.5% | | | Нүүрс болон түгээмэл тархацтай ордод 2.5%, Бусад ашигт малтмал болон экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүнд 5% |
| 2 | Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын тухай хууль | 0 | | | Зэсийн баяжмал болон алтны дэлхийн зах зээлийн үнэ зэвцд 2600 ам.доллар/тн, алтанд 500 ам.доллар/унц-аас дээш болсон тохиолдолд үүнээс дээш гарсан үнийн дүнгийн зөрүүнээс олсон орлогын 68%-д татвар ногдуулна. |
| 3 | Хүн амын орлогын албан татвар | 200 мянга хүртэл 10%, 200-400 мянга хүртэл 20%, 400 мянгаас дээш 30% | | | Шатлал харгалзахгүй 10% |
| 4 | Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль | 0-100 сая -15%, >100 - 40% | 0-100 сая -15%, >100 - 30% | | 0-3 тэр Бум 10%, >3 тэр Бум 25% |
| 5 | НӨАТ-ын татвар | > 10 сая -15%, < 10 сая 0%, Алт - 0% | | | Шатлал харгалзахгүй 10%, Алт 0% |
| 6 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | | | 6% | |
| 7 | Автобензин, дизель түлшний албан татвар | | Автобензин -90 хүртэл октантай 20350төг/тн, 90-ээс дээш октантай 25700төг/тн, ДТүшл -2140төг/тн | | |
| 8 | Ус ашигласны төлбөр | Гадаргын болон гар худгийн ус 1-5 төг/м3, газрын гүний ус /гүйцдвэрлэл/ 1-20 төг/м3 | | Гадаргын болон гар худгийн ус 80 төг/м3, Газрын доорхи гүний ус 100 төг/м3 | |
| 9 | Газрын төлбөр | | | Таршлал хадлан 1га-0.01-0.03%, Суурийн 0.1-1.0% | |

* - Ашигт малтмалын шинэчилсэн хууль 2006 оны 07 саргаас, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын хууль 2006 оны 5 саргаас хэрэгжсэн.

** - Татварын ерөнхий хууль өөрчлөгдсөн.

2006 онд Ашигт малтмалын тухай хуулийг шинэчилсэн бол Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын хуулийг шинээр бий болсон.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр эхний 1-3 жилд 2-3 дахин нэмэгдсэн бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмших хугацаа 2 жилээр өссөн байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 1.5-3 дахин өссөн ба түгээмэл тархацтай ордод 1-

3 дахь жилд өөрчилөгдөөгүй, харин 4-6 дахь жилд 1.5 дахин, 7 ба түүнээс дээших жилд 2 дахин өсжээ. Харин нөөцийн төлбөр алтны шороон ордод 2.5%-р буурсан, алтны үндсэн ордод 2.5%-р өссөн ба нүүрс болон түгээмэл тархацтай ордод өөрчилөгдөөгүй байна.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар /ЗБҮӨТ/ -ыг зэс болон алтад ногдуулах тухай хуулийг баталсан ба бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тооцох дэлхийн зах зээлийн үнэ харгалзан 2600 ам.доллар/тн, 500 ам.доллар/тн –оос давсан үнээс олох орлогын 68%-д ногдуулах юм.

Монгол Улс Ашигт малтмалын тухай хуулиндаа Уул уурхайн салбар дахь санхүүгийн бүртгэлийг дараах онцлогтойгоор бүртгэхээр тусгасан бөгөөд 1997 онд баталсан хуулийн 63-р зүйлд энэ тухай хуульчилсан байдаг бол 2006 оны шинэ хуулийн 61-р зүйлд энэ заалт орсон юм.

- Хайгуул ажлын болон уурхайн эдэлбэрийг ашиглалтанд бэлтгэсэн зардлуудыг үйлдвэрлэл явуулж эхлэснээс хойш 5 жилийн хугацаанд тогтмол хэмжээгээр үйлдвэрлэлийн зардалд оруулж, шимтгэлийн сан байгуулна,
- Уул уурхайн үйлдвэрлэлийн тухайн жилд гарсан алдагдлыг уг алдагдал гарсан санхүүгийн жил дууссанаас хойшхи 2 жилийн хугацаанд албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно.
- Үйлдвэрлэл болон дэд бүтцэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарцуулсан эд хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн санг тэдгээр барилга, байгууламжийн ашиглагдах хугацаанд тогтмол хэмжээгээр байгуулж, тэдгээртэй холбогдон гарах зардлыг тухайн санхүүгийн жилийн үйлдвэрлэлийн зардалд оруулан тооцно.
- Уул уурхайн үйлдвэрлэл явуулахад зайлшгүй шаардлагатай хийгдсэн бүх төрлийн засварын зардлыг үйлдвэрлэлийн зардалд тооцно.

2007 оноос НӨАТ, Аж ахуйн нэгж болон Хүн амын орлогын албан татварын хувь хэмжээ өөрчлөгдсөн юм. НӨАТ-ийн татвар 33%-иар буурсан бол Хүн амын орлогын албан татвар шатлалгүйгээр 10 % болж буурсан байна.

3.2. Татварын ачааллын судалгаа

Уул уурхайн салбар дахь Татварын ачааллыг борлуулалтын орлогод эзлэх татвар төлбөрийн нийт хэмжээгээр тооцож байна. Судалгаа хийх загварыг 2000 оны 3-р сарын дэлхийн уул уурхайн татварын харьцуулсан судалгаанд дэлгэрэнгүй тодорхойлсон бөгөөд үүнийг *Global Mining Taxation Comparative Study 2nd Edition* хэмээх энэхүү судалгааг НҮБ, Дэлхийн банк, Колорадогийн уул уурхайн сургуулийн профессор Ж. Отто хийж загварыг тодорхойлсон бөгөөд уг загварыг уул уурхайн санхүүгийн тогтолцооны харьцуулсан шинжилгээнд өргөн хэрэглэгддэг байна. Энэ үзүүлэлт нь аж ахуйн нэгжийн бүх татварын хувийг бус зөвхөн нийт борлуулалтаас олсон орлогод ногдох татварын хувь хэмжээг л харьцуулдаг үзүүлэлт гэдгийг анхаарна уу.

/Загварыг дараах байдлаар томъёолов/

ТА=ТТХ/БО

ТА - Татварын ачаалал

ТТХ - татвар, төлбөр хураамжууд

БО - борлуулалтын орлого

Ж. Оттогийн аргачлалаар дараах загвар төслөөр алт болон зэсэнд татварын ачааллыг тооцов.

1.3.2. дугаар хүснэгт


| Д/д | Үзүүлэлтүүд | Зэсийн төсөл | Алтны төсөл |
|-----|-----------------------------------------|-----------------------------------------------------|--------------|
| 1 | Нөөц | 3.6 сая.тн Си-ын баяжмал, 30.7 мян.тн Мо баяжмал | 218.5 кг |
| 2 | Жилд борлуулах бүтээгдэхүүн | 182.2 мян тн Си баяжмал, 1539 кг Мо баяжмал | 109 кг |
| 3 | Ашиглалтын өмнөх Уурхайн Бэлтгэл үе шат | 1 жил | 0 |
| 4 | Уурхайн ажиллах хугацаа | 20 жил | 2 жил |
| 6 | Зээлийн хугацаа | 9 жил | |
| 8 | Хөрөнгө оруулалт | 200.0 сая ам. \$ | |
| 9 | Хайгуулын ажлын зардал, ГЭЗҮ | 10.0 сая ам.\$ | 20 сая төг |
| 10 | Уурхайн нөхөн сэргээлтийн зардал | 5.0 сая ам.\$ | 10.0 сая төг |
| 11 | Үйлдвэрлэлийн зардал | | 420 \$/унц |
| 12 | Борлуулалтын үнэ | | 590 \$/унц |

Алтны төсөл нь 2 жил ашиглах нөөцтэй шороон орд, харин зэсийн төсөл нь Цагаан суваргатай төстэй зэс молбидений орд ашиглах төсөл гэж үзлээ.

Дээр томъёолсон загварын дагуу татварын ачааллыг төсөл тус бүр тооцов.

1.3.3. дугаар хүснэгт

| Татварын ачаалал | Он | | | | | | | | | | |
|------------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|
| | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 |
| Зэс, % | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 20 | 20 | 23 | 24 |
| Алт, % | 12 | 17 | 19 | 17 | 17 | 12 | 12 | 9.2 | 19 | 19 | 20 |




(1.3.1. дүгээр зураг) Татварын ачаалал

Зэсийн төслийн хувьд татварын ачаалал 1997-2003 он хүртэл тогтмол 23 хувьтай байсан бол 2004, 2005 онд 20% болж буурсан байна. Харин 2006 онд 23%, 2007 онд 24% хүртэл өссөн байна.


Алтны төслийн хувьд 1997 онд 12%-тай байсан бол 1998, 1999 онуудад өсөж 17%, 19% болсон бол 2000, 2001 онуудад 17%, 2002, 2003 онуудад 12%, 2004 онд 9.2% хүртэл буурсан байна. Харин 2005 онд 13%, 2006 онд 19% болж өссөн бөгөөд 2007 оноос 20% хүртэл өсөхөөр байна.

1.3.1. дүгээр зурагаас харахад Зэс болон алтны төслийн хувьд татварын ачаалал 2004 онд хамгийн бага хувьтай буюу татварын хөнгөлөлтэй жил байсан байна. Энэ нь тус онд аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар буурсантай холбоотой юм.

Профессор Ж. Оттогийн тооцоолсон загвараар тооцсон татварын ачааллыг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын 2003-2006 оны тайлан мэдээлэлд үндэслэн тооцсон татварын ачаалалтай харьцуулж үзвэл.



(1.3.2 дугаар зураг)




(1.3.3. дугаар зураг)


Зураг 1.3.2, 1.3.3. дугаар зурагуудаас харахад Ж.Оттогийн загвараар тооцсон татварын ачаалал нь бодит гүйцэтгэлтэй нилээн ойрхон гарч байгааг харж болно. Зэсийн хувьд 2006 онд татварын ачаалал 39.1% гарсан нь дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ өндөр байсантай холбоотой юм. Зэсийн үнийг дунджаар 4000-5000 ам.доллар/тн тооцвол татварын ачаалал Ж. Оттогийн загвараар тооцсонтой ойролцоо гарах юм.

Эндээс профессор Ж. Оттогийн загвараар татварын ачааллыг тооцох нь тохиромжтой гэж үзэн 2007 оны ачааллыг тооцвол алтанд 20%, зэсэнд 24% байна. Энд алтны үнийг 590 ам.доллар/унц, зэсийн үнийг 5000 ам.доллар/тн – оор тооцсон.

УИХ-аас 2007 онд аж ахуйн нэгж байгууллагын болон хүн амын орлогын албан татвар, НӨАТ-ыг бууруулж уул уурхайн үйлдвэр эрхлэгчдэд таатай нөхцлийг бий болгож өгсөн билээ. Татварын бууралтаа зэс, алтнаас авахаар тооцоолж татварын ачаалал 2007 онд алтны хувьд 20%, зэсийн хувьд 24% хүртэл өсгөж дарамт үүсгэсэн гэж үзэж болох юм. /2006 оны гүйцэтгэл/



(1.3.4. дүгээр зураг) Улс орон нутгийн төсөвт төлөх татварт эзлэх хувь /алт/



(1.3.5. дугаар зураг) Улс орон нутгийн төсөвт төлөх татварт эзлэх хувь /зэс/

1.3.4. дүгээр зурагаас харахад Алтны салбарын хувьд улс болон орон нутагт төлдөг татварт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 47-48%, Орлогын албан татвар 10-25%, Лицензийн төлбөр 2-4%, Газрын төлбөр 1-2%,

НДШ 6-11%, бусад 20-30% эзэлдэг байсан боловч 2006 оноос ЗБҮӨТ бий болж энэ татвар нь нийт татварын 46%-ыг эзлэх болсон бөгөөд энэ нь орлогын албан татварыг бууруулсан байна. АМ-ын тухай хуулиар нөөцийн төлбөрийн төлбөр төлөх хувь хэмжээ буурсан тул энэ хэмжээгээр төлбөр буурсан байна. Харин газар, ус, лизензийн төлбөр бага хуваарь өсжээ.

График №5-аас харахад 2006 оноос өмнө зэсийн салбарын хувьд улс болон орон нутагт төлдөг татварт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 6-10%, Орлогын албан татвар 40-65%, Газрын төлбөр болон НДШ тус тус 5-9%, бусад 20-30% эзэлдэг байсан боловч 2006 оноос ЗБҮӨ-ийн татвар бий болж энэ татвар нь нийт татварын 50%-ыг эзлэх болсон бөгөөд энэ нь орлогын албан татварыг 35% хүртэл бууруулсан, мөн бусад татварууд буурч байгаа нь графикаас харагдаж байна.

Дээрх тооцоололд буюу 2006 онд алтны үнэ дунджаар 610 ам.доллар/унц байхад нийт татварын зардалд эзлэх ЗБҮӨТ 46%-ыг эзэлж байсан. Хэрэв ЗБҮӨТ үгүй бол 2007 онд алтны салбарын татварын ачаалал 10% хүртэл буурах байжээ. Харин Зэсийн үнэ дунджаар 6722 ам.доллар/тн байсан ба энэ тохиолдолд нийт татварын зардалд эзлэх ЗБҮӨТ 50%-ыг эзэлж байсан. Хэрэв ЗБҮӨТ үгүй бол 2007 онд Зэсийн салбарын татварын ачаалал 18% хүртэл буурах байжээ.

Дүгнэлт:


- Татварын ачаалал өсөхөд ЗБҮӨ-ийн татвар голлон нөлөөлсөн ба мөн АМ-ын тухай хуулийн зарим заалтууд бага зэрэг нөлөөлсөн байна.
- Уул уурхайн салбар дахь татварын ачаалалд ЗБҮӨ-ийн татвар 50% нөлөөлж байгаа бөгөөд энэ татварын хувь хэмжээ алт болон зэсийн дэлхийн зах зээлийн үнэ ханшаас хамааран өөрчилөгдөх юм. Өөрөөр хэлбэл уул уурхайн салбарт дахь татварын ачаалал тогтворгүй буюу үнийн өөрчлөлтөөс хамааран өөрчилөгдөж байхаар байна.

Иймд алт болон зэсийн үнэ өсөхөд татварын ачаалал хэрхэн өөрчлөгдөхийг тооцож үзэе.

Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ ойрын хэдэн жилдээ өсөх хандлагатай байгаа талаар банк, санхүүгийн нэртэй экспертүүд болон мэргэжлийн судлаачид үзэж байна. Харин зэсийн үнэ хэлбэлзэлтэй байх хандлагатай байна. Иймд алт болон зэсийн үнийн өсөлтөнд татварын ачааллыг тооцсоныг 1.3.4. дүгээр хүснэгтэд харуулав.

1.3.4. дүгээр хүснэгт

| Алтны үнэ ам.доллар/унц | Татварын ачаалал | Нийт зардалд эзлэх хувь | Зэсийн үнэ ам.доллар/тн | Татварын ачаалал | Нийт зардалд эзлэх хувь |
|----------------------------|---------------------|-------------------------------|----------------------------|---------------------|-------------------------------|
| 700 | 28% | 8.9% | 4000 | 16% | 12.4% |
| 750 | 32% | 8.9% 8.9% | 5000 | 24% | 15.8% |
| 800 | 34% | 8.8% | 5600 | 26% | 16.4% |
| 850 | 37% | 8.9% | 6000 | 29% | 17.1% |
| | | | 6500 | 32% | 17.5% |
| | | | 7000 | 36% | 17.6% |




(1.3.6. дугаар зураг) Татварын ачаалал


Ашигт малтмалын тухай хуулийн 61-р зүйлд заасан санхүүгийн бүртгэлийн дагуу татварын ачааллыг тооцвол өмнө нь тооцож байснаас он тус бүрээс 1-2 хуваарь буурч байна. 2007 онд алтны төслийн хувьд 19%, зэсийн төслийн хувьд 23% болж нэг нэг хувиар буурсан байна. 1.3.6. дугаар зурагт үзүүлэв

3.3. Бусад улсуудын татварын ачаалал

Монгол Улсын Уул уурхайн салбарын татварын ачааллыг уул уурхай хөгжсөн бусад улс орнуудын татварын ачаалалтай харьцуулан 1.3.7, 1.3.8. дугаар зурагуудад харуулав



(1.3.7. дугаар зураг) Татварын ачаалал /алт/



(1.3.8. дугаар зураг) Татварын ачаалал /зэс/

Зураг 1.3.7, 1.3.8 аас харахад Монгол Улсын уул уурхайн салбарын татварын ачаалал алт болон зэсийн аль алинд нь дэлхийн улс орнуудынхаас өндөр байгаа ба дундаж татварын ачааллаас 2 дахин их байна. Энэ нь Монгол Улсын уул уурхайн салбар татварын дарамттай болохыг харуулж байгаа бөгөөд үнийн өсөлтөөс хамааран татварын ачаалал хэлбэлзэж байгаа нь татварын тогтворгүй улс болохыг харуулж байна.

Хэрвээ ЗБҮӨТ-ыг эс тооцвол татварын хэмжээ 2 буурч дэлхийн бусад орнуудын дундаж түвшинтэй ойролцоо болох бөгөөд энэ хэмжээгээр хөрөнгө оруулалтыг татах, татварын таатай орчноор бусад улсуудтай өрсөлдөх хэмжээнд хүрэх юм.

3.4. Дүгнэлт

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар Монгол Улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 60-70%, ДНБ-ний 20-30% үйлдвэрлэдэг томоохон салбар боллоо. Цаашид ч энэ салбар үйлдвэрлэлийн тэргүүлэгч салбар байсаар байх нь ойрын жилүүдэд ашиглалтанд орох Оюу толгой, Тавантолгой, Цагаан суварга зэрэг томоохон ордуудын ирээдүйгээс харагдаж байгаа юм. Иймээс Монгол Улсын засгийн газраас уул уурхайн салбарыг үйлдвэрлэлийн тэргүүлэгч салбар хэмээн зарлаж улс орны эдийн засагт доривтой ахиц, хөгжил дэвшлийг авчирна гэж үзэн уг салбарыг төрийн бодлогын хүрээнд дэмжиж ажиллах зорилт тавин ажиллаж байна.

Монгол улс 2007 онд орлогын албан татварын ерөнхий хувь хэмжээг бууруулсан боловч уул уурхайн салбар дахь татварын ачаалал буурсангүй харин ч өсжээ. Цаашид ч өсөх хандлагатай байна. Татварын ачаалал өсөх болсон гол шалтгаан нь ЗБҮӨТ-тай холбоотой юм. Энэ татвар нь салбарын татварын орчин тогтвортой биш, үнийн өөрчлөлттэй холбоотойгоор тогтворгүй хэлбэлзэж байх нөхцөл байдалыг бий болгож байна.

Ашигласан материал, интернэтийн эх сурвалж

1. Ц. Эрдэнэ, О. Зориг, Уул уурхайн салбарын татвар санхүүгийн тогтолцооны харьцуулсан судалгаа, 1999 он
2. Д. Жаргалсайхан, О. Зоригт, Д. Дашзэвэг, Д. Болор, Уул уурхайн салбарын татвар санхүүгийн тогтолцооны харьцуулсан судалгаа, 2000 он
3. Б. Батзул, Монгол Улсын уул уурхайн салбарын татварын таатай орчныг бүрдүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татах зарим асуудал, 2004 он
4. Хууль тогтоомж, эмхэтгэлүүд,
 - i. Монгол улсын Татварын ерөнхий хууль
 - ii. Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль
 - iii. Монгол улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
 - iv. Монгол улсын Орлогын албан татварын тухай хууль
 - v. Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
 - vi. Монгол улсын Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын хууль,

5. Интернэтийн эх сурвалж:

1. <http://www.kitco.com/market>
2. <http://www.lme.com>
3. <http://www.metalprice.com>
4. <http://www.copper.org>
5. <http://www.neatideas.com>
6. <http://www.Bloomsbury Minerals Economics.com>

7. <http://www.basemetals.com>
8. <http://www.copper.org>
9. <http://www.bgr.bund.de>
10. <http://www.ft.com>
11. <http://news.tradingcharts.com>
12. <http://www.goldtrend.de>
13. <http://www.interfax.com>
14. <http://www1.metalbulletin.com>
15. <http://www.mines.edu>
16. <http://www.metalseconomics.com>
17. <http://gdr.nrcan.gc.ca>
18. <http://mmsd1.mms.nrcan.gc.ca>
19. <http://www.mining-journal.com>
20. <http://www.miningweekly.co.za>
21. <http://www.natural-resources.org/>
22. <http://www.theminingnews.org>
23. <http://minerals.usgs.gov>
24. <http://www.gold.org/>
25. <http://www.mining-journal.com>

-----ooOoo-----